

“АРИГ ГАЛ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04 дугаар сарын
29-ны өдөр

Дугаар 01/15

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын саналын дүнг батлах тухай

“Ариг гал” ХК - ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 2015 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 01/15 тоот тогтоолыг үндэслэн, “Компанийн тухай хууль”-ийн 69.1 дүгээр зүйлд заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын ердийн олонхийн санал буюу хувийн саналаар компанийн 2014 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тайланг, санал буюу хувийн саналаар ТУЗ-өөс Компанийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг тус тус баталсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын ердийн олонхийн санал буюу хувийн саналаар компанийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга:

Х.Эрдэнэбаяр

Х.Оюунгэрэл

“АРИГГАЛ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04 дүгээр сарын
29-ны өдөр

Дугаар 02/15

Улаанбаатар хот

Компанийн удирдлагыг батлах
батлах тухай

“Ариг гал” ХК - ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 2015 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 01/15 тоот тогтоол, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 63.4 ,75.4 дүгээр заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцогчдын кумулятив санал буюу%-ийн саналаар С.Мөнхжаргалыг, кумулятив санал буюу%-ийн саналаар Д.Гиваапилыг, кумулятив санал буюу%-ийн саналаар Б.Ёндонжамцыг, кумулятив санал буюу-ийн саналаар Д.Мөнхбатыг, кумулятив санал буюу%-ийн саналаар Х.Ханияг, кумулятив санал буюу%-ийн саналаар С.Баяр нарыг “Ариг гал” ХК-ийн ТУЗ-ийн энгийн гишүүнээр сонгосныг баталсугай.

2. Хуралд оролцогчдын кумулятив санал буюу %-ийн саналаар Б.Аюушийг, кумулятив санал буюу %-ийн саналаар Э.Бямбажавыг, кумулятив санал буюу %-ийн саналаар Б.Болдыг “Ариг гал” ХК-ийн хараат бус гишүүнээр сонгосныг баталсугай.

3. ТУВ-ийн хурлаас ТУЗ-ийн дарга болон аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороодыг сонгож, компанийн үйл ажиллагааг удирдлага, хяналтаар ханган ажиллаж, Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхийг ТУЗ-д зөвшөөрсүгэй.

Хурлын дарга

Х.Эрдэнэбаяр

Тооллогын комиссын дарга:

Х.Оюунгэрэл

“АРИГ ГАЛ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04 дүгээр сарын
29-ны өдөр

Дугаар 03/15

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа эзэмшигчдэд
2014 оны үр дүнгээр олгох ногдол
ашгийг батлах тухай

“Ариг гал” ХК - ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 2015 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 01/15 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцогчдын ердийн санал буюу% ийн саналаар компанийн 2014 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийг нэгж хувьцаанд 42.51 төгрөг /дөчин хоёр төгрөг 51 мөнгө/ буюу нийт 144,080,500.00₮ /нэг зуун дөчин дөрвөн сая наян мянга таван зуун төгрөг 00 мөнгө/- өөр баталсугай.

2. Хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашигт зарцуулагдах 144,080,500.00₮ /нэг зуун дөчин дөрвөн сая наян мянга таван зуун төгрөг 00 мөнгө/- ийг компанийн хуримтлагдсан ашгаас гаргахыг гүйцэтгэх захирал /Х.Хания/-д зөвшөөрсүгэй.

3. Компанийн хөрөнгийн бололцоотой үеийг тааруулан Ногдол ашгийг нийтэд зарлан, олгох үйл ажиллагааг зохицуулан гүйцэтгэхийг гүйцэтгэх захирал /Х.Хания/-д даалгасугай.

Хурлын дарга

Х.Эрдэнэбаяр

Тооллогын комиссын дарга:

Х.Оюунгэрэл

“АРИГ ГАЛ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04 дүгээр сарын
29-ны өдөр

Дугаар 04/15

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын болон ТУЗ-ийн үйл ажиллагааны
2015 оны зардлын төсөв батлах тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 59.9, 62.1.13 дугаар зүйлийг удирдлага болгон, “Ариг гал” ХК - ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 2015 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 01/15 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцогдын ердийн олонхийн санал буюу%-ийн саналаар компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн 2015 оны зардлын төсвийг 52764.0 мян.төг /тавин хоёр сая хоёр долоон зуун жаран дөрвөн мянган/-өөр баталсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн үйл ажиллагааны 2015 оны зардлын төсөвт зарцуулагдах 52764.0 мян.төг /тавин хоёр сая хоёр долоон зуун жаран дөрвөн мянган/-ийг компанийн үйл ажиллагааны зардлаас гаргахыг гүйцэтгэх захирал /Х.Хания/-д зөвшөөрсүгэй

Хурлын дарга

Х.Эрдэнэбаяр

Тооллогын комиссын дарга:

Х.Оюунгэрэл

“АРИГ ГАЛ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04 дүгээр сарын
29-ны өдөр

Дугаар 05/15

Улаанбаатар хот

Компанийн хаягийн өөрчлөлтийг
дүрэмд тусгаж, оруулсан
өөрчлөлтийг батлах тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 62.1.1 дугаар зүйлийг удирдлага болгон, “Ариг гал” ХК - ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 2015 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 01/15 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Хувьцаа эзэмшигчдийн хуралд орологчдийн санал буюу% саналаар “Ариг гал “ ХК-ийн хаягын өөрчлөлтийг тусгаж дүрэмд оруулсан өөрчлөлтийг баталсугай.

2. Компанийн дүрэмд оруулсан өөрчлөлтийг тусгаж шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт оруулан бүртгүүлж,үйл ажиллагаанд мөрдүүлэхийг гүйцэтгэх захирал /Х.Хания/-д үүрэг болгосугй.

Хурлын дарга

Х.Эрдэнэбаяр

Толлогын комиссын дарга:

Х.Оюунгэрэл